



Thomas Jefferson Middle School

ОУБДБХ-ийн 10-р сарын мэдээ



Энэ сарын шилдэг сурагч: НЭЭЛТТЭЙ ХАНДЛАГА

ОУБХ-ийн сурагчид бид найман сэдвээр зургаан дэлхий даяарх үйл явцыг суралцах замаар **нээлттэй хандлага** эзэмшихийг эрмэлздэг. Бид олон төрлийн суралцах үйл явц, үнэлгээгээр суралцагчдыг олон янзын



өнцгөөс харсан агуулгыг ойлгох чадварт суралцуулахыг зорьдог.

Манай сурагчдын сонгосон шилдэг, нээлттэй хадлагатай суралцагчид бол: **Далайн гахай- Ray Briscoe, Луу- Sami Stewart, Бүргэд - Quin Castelli, Матар- Dakota Bannach, Эээн хаан- Sarah Eichorn, Шар шувуу- Berivan Hanish, Оцон шувуу- Cheyenne Klapper, Галт шувуу- Bilguun Zolzaya, Далайн муур- Matthew Abramson.**

Эх сурвалж :<https://pixabay.com/en/sky-freedom-happiness-relieved-2667455/>

Сургалтын хөтөлбөр

Өнгөрсөн сард бид хэл, уран зохиол (Англи хэлний үр чадвар) болон математикийг голчилж үзсэн бол энэ сард хувь хүн ба нийгэм (нийгмийн ухаан), шинжлэх ухаанд анхаарлаа хандуулж байна. Эхний жилд (6-р анги) түүхийн хичээлээр сурагчид эртний уугуул индиан америкчуудын талаар суралцаж байгаа ба хоёр дахь жилд (7-р анги) бид өргөжин тэлж буй үндэстэн, иргэншлийн тухай судлах болно. Гурав дахь жилд (8-р анги) бид биет болон соёлын газарзүйн тухай судална.

Шинжлэх ухааны хичээлд эхний жилийн сурагчид одон орны тухай судалж, хоёр дахь жилд бид шинжлэх ухааны судалгаа, гурав дахь жилд бодисыг хэмжих тухай үзэж, Шинжлэх Ухааны Үзэсгэлэнгийн өдрийг эхлүүлнэ.

Анги бүрд холбогдох хичээлийн талаар [эндээс үзнэ үү](#).

Хэл суралцахад баримтлах ОУБХ-ийн бодлого




Манай Jefferson сургуулийн хэл суралцахад баримтлах журам бэлтгэгдэн гарлаа. Jefferson сургуульд дэлхийн өнцөг булан бүрийн сурагчид суралцаж байна. Манай хэл сурах журмын дагуу бүх сурагч нэмэлт хэл сурч, англи хэл суралцахад

дэмжлэг авч, мөн англи хэл эх хэл нь бус сурагчид өөрсдийн эх хэлээр суралцах дэмжлэг авна. Бид америк дохионы хэл, араб, хятад, франц, латин, испани хэлний сургалтуудыг санал болгож байгаадаа баяртай байна. [Манай журам одоогоор төсөл хэлбэртэй байгаа ба \(эндээс уншина үү\)](#) бид аливаа санал хүсэлтийг хүлээн авна. Эх сурвалж: pixabay.com/en/welcome-words-greeting-language-905562/

ДБХ-ийн анги ба бодит үнэлгээ

Өнгөрсөн сард бид сурагч төвтэй сургалтад анхаарлаа хандуулсан ба энэ сард бид бодит үнэлгээний тухай бичсэн. Хатагтай Voda-н гэр бүл, хэрэглээний шинжлэх ухааны анги хамгийн гоё амттай олон улсын пиццаны уралдаанд оролцсон. Сурагчид грек, орос, франц, мексик пицца хийсэн. Амттай байдлын түвшнийг тусгай тодорхойлолтын дагуу ОУБ-ын үнэлгээг ашиглаж тодорхойлсон. Бараг бүх пицца мастерын түвшинд байна гэсэн үнэлгээ авсан. Доминос, Папа Жон пиццаны газрууд болгоомжтой байгаарай. Шар хүрэмтнүүд дэлхийн пиццаг нийлүүлнэ! Гэрэл зургийг Malinosky



Олон нийтийн төсөл

Олон нийтийн төслийг эхлүүлж байна! Даруй 139 сурагчдын баг олон нийтэд тустай үйлийн санаагаа Олон нийтийн төсөлд зориулж дэвшүүлсэн байна. Хамгийн их дэмжлэг авсан санаачилга нийгмийн асуудалд шууд туслах болон олон нийтийн анхаарлыг хандуулахад чиглэжээ.



Олон нийтийн төсөл 8-р ангийнхны хувьд ямар нэг сүнсний баяр биш харин хичээлийн хөтөлбөртэй холбоотой төсөл юм. Хамгийн нийтлэг сэдвүүд хувь хүн, нийгэм, шинжлэх ухаан, урлагтай холбоотой. [Дэлгэрэнгүй мэдээллийг эндээс үз.](#)

Олон улсын үйл явдал

Дэлхий даяар [дүрвэгсдийн асуудал](#) хурцдахын хэрээр Jefferson сургуулийн сурагчид 1930-аад оны Герман, 1990-ээд оны Куба, 2015 оны Сири улсын залуу дүрвэгчийн тухай Alan Gratz-ын бичсэн *Дүрвэгсэд* номыг уншив. Унших үйл явцад дэмжлэг үзүүлэхийн тулд манай номын сан тус зохиолчтой интернэтээр уулзаж, яагаад энэ номыг бичих болсон тухайгаа яриу.



Энэ ном TJ сургууль дээр хамгийн их сонирхол татаж байлаа. Номыг хэл, уран зохиол болон хувь хүн, нийгмийн хичээлд хэрэглэсэн.

Жефферсонын нэрэмжит сургууль олон нийтэд



10-р сарын 19-ны Ургацын баяраар сурагчид олон нийтэд зориулж дуулж, бүжиглэв. Сурагчид "Greatest Showman" дууг дуулж, Кени үндэстний бүжиг бүжиглэсэн. Мөн Jefferson сургуулийн НҮБ-ын загвар

клуб Мариланд мужийн Holton-Arms сургууль дээр анхны хуралдаа оролцов. Манай сурагчид Венесуэл, Сингапур, бусад олон улсыг төлөөлөв.

Эх сурвалж:

<https://twitter.com/DJordanAPS/status/1053411664178102272>

Удахгүй болох арга хэмжээ, үйлчилгээний хуваарь

- 11 сарын 7-оос эхэлж Лхагва гараг бүр номын санд Олон нийтийн төслийг судлахад туслах
- Мягмар гараг бүр 17:00 цагт дугуй засахад туслах Phoenix Bikes дэлгүүрт, 909 S. Dinwiddie St ([дэлгэрэнгүй мэдээллийг эндээс](#))
- Лхагва гараг бүр 18:30 цагт тахианы мах уутлахад туслах AFAC-т, 2708 S. Nelson St, ([дэлгэрэнгүй мэдээллийг эндээс](#))
- Хоолны автобус зохицуулах бол [Mr. Malinosky](#) холбоо барина уу.
- 8-р ангийн Олон нийтийн төслийг дуусгах өдөр 10 сарын 29
- [Сайн дурын ажлын хуваарь энд бий.](#)